

**“Бэрх Уул” ХК**

**2023 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

***УЛААНБААТАР ХОТ 2024 ОН***

**АГУУЛГА**

**1. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ**

- КОМПАНИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ
- КОМПАНИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА
- КОМПАНИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ
- ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
- ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД
- НООГДОЛ АШИГ

**2. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН БАЙДАЛ**

- САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
- ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
- ХЭЛТЭС ТАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
- ХҮНИЙ НӨӨЦ

**3. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛУУД**

- 2023 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД
- КОМПАНИЙН ИРЭЭДҮЙ, ТӨЛӨВЛӨГӨӨ

### КОМПАНИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Бэрхийн уурхай нь Хэнтий аймгийн төв Чингис хотоос зүүн хойшоо 70 километрт, Батноров сумын нутаг Бэрхийн уулын баруун хойд үзүүрт оршдог.

1954 оны 9 дүгээр сард Батноров сумын нутагт Жоншит толгойн ордын жоншийг ил аргаар ашиглах болсноор Бэрхийн уурхайн үйл ажиллагаа эхэлсэн түүхтэй бөгөөд эдүгээ 66 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

1940-өөд оны сүүлчээр Зөвлөлт-Монголын геологичдын хайгуулаар жоншны нөөц баялагтай олон газар илрэн судлагдсаны нэг нь Батноров сумаас хойш орших Ямаатад Зөвлөлтийн геологич Ковалевскийн жоншны орд газрыг олж нээснээр тэр үед Ямаат буюу Ковалевскийн уурхай гэж нэрлэгдсэн юм. 1954 оны есдүгээр сард Батноров сумын нутагт Гурван бухтын /Жоншит толгой/ ордын жоншийг ил аргаар ашиглах болсноор Бэрхийн уурхайн үйл ажиллагаа эхэлсэн юм.

Тус уурхай 1954-1957 онд Санжаагийн уурхай гэж нэрлэгдэж байгаад 1957 онд дээд газрын шийдвэрээр Бэрхийн уулын нэрээр нэршин одоог хүртэл гадаад, дотоодод энэ нэрээрээ танигдсан байна.

1957 онд Совмонголметалл нийгэмлэг Монгол улсын уул уурхайн салбарын хөгжилд түүхэн үүргээ гүйцэтгээд татан буугдсан учир Бэрхийн уурхай нь тэр үеийн өнгөт металлын үйлдвэр, Уурхайнуудыг удирдах газар, Геологи-уулын үйлдвэрийн яам, Аж үйлдвэрийн яам, Түлш эрчим хүч, үйлдвэр геологийн яамны харьяанд 1974 он гартал арван долоон жил бие даан ажиллаж, уул уурхайн салбарын түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн юм.

Бэрхийн уурхай нь 1960-1970 онд жилд 35.0-40.0 мян/тн жонш экспортод гаргадаг, уурхайчид 400-500 уртааш метр нэвтрэлтийг хийдэг байсан бөгөөд нийт 360-400-аад ажилчидтай байсан.

***1971 онд Монгол улсын уул уурхайн салбарт оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж Алтан гадас одонгоор шагнасан.***

1970-аад оны эхэн үеэс тэр үеийн социалист орнуудад нийгмийн үйлдвэрлэлийн төрөл бүрийн салбарт хамтарч ажиллах гэрээ хэлэлцээрүүд олноор байгуулагдаж, тэдгээрийг шуурхай хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ арга хэмжээний хүрээнд 1973 оны 2 дугаар сарын 24-нд БНМАУ ЗХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр Монгол-Зөвлөлтийн хамтарсан аж ахуйн анхны үйлдвэр “Монголсовцветмет” нэгдлийг байгуулсан байна. Бэрхийн уулын үйлдвэрийг 1974 оны 9 дүгээр сарын 23-нд “Монголсовцветмет” нэгдлийн бүрэлдэхүүнд оруулахаар шийдвэрлэсэн байна.

Бэрхийн уурхай “Монголсовцветмет” нэгдлийн бүрэлдэхүүнд орсон цагаас үйлдвэрлэлийн бүхий л шат дамжлага нь улам боловсронгуй болж, удирдлага зохион байгуулалтын цоо шинэ арга барил нэвтэрч, үндэсний боловсон хүчин Зөвлөлтийн мэргэжилтэн, инженер техникийн ажилчидтай мөр зэрэгцэн хөдөлмөрлөж эхэлсэн. Энэ үеэс эхлэн уулын цех, зарим туслах цехүүдийг орон сууц, нийгэм аж ахуйн барилга байгууламжуудын хамт ЗХУ-ын хүч хөрөнгөөр өргөтгөх, геологи хайгуулын ажлын уулын гүний малталт нэвтрэх зэрэг ажлууд хийгдсэн.

Энэ үеийн уурхай нь уулын цех, цахилгаан станц, засвар механикийн цех, автограш, барилгын хэсэг, компрессорын станц, Дорнод аймаг дахь жонш борлуулах тасаг, материалын төв склад, пүү, тэсрэх

## 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

---

материалын склад, гал команд, уурхайн захиргаа гэсэн үндсэн ба туслах цех хэсгүүдтэй хорь гаруй орон сууц, хүн эмнэлэг, эмийн сан, холбоо, ерөнхий боловсролын дунд сургууль, ажилчны клуб, кино цэг, номын сан, зочид буудал, биеийн тамирын заал, халуун усны газар, химийн лаборатори, уурхайчдын гуанз, сувиллын газар, банкны тооцооны касс, худалдаа бэлтгэлийн анги, оёдлын цех зэрэг соёл үйлчилгээний газруудтай уурхайчдын хотхон болсон байна.

Дээрх өргөтгөл шинэчлэлтийн ажил хийгдэж, барилга байгууламж ашиглалтад орсноор уурхайн үндсэн цех дамжлагуудын хүчин чадал хоёроос, гурав дахин нэмэгдэж, жилд 160.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтай болсон бөгөөд орчин үеийн уул уурхайн өндөр бүтээлтэй машин техник, тоног төхөөрөмжөөр тухай бүрд нь хангаж ирсний үр дүнд, 1980-аад он гэхэд тус үйлдвэрийн газрын доорх бүх дамжлага, бүрэн механикжиж, тэдгээрийг эзэмшин ашиглах төрөл бүрийн мэргэжлийн үндэсний боловсон хүчин, инженер техникийн ажилчдаар бүрэн хангагдсан байсан. 1985 он хүртэл “Монголсовцветмет” нэгдлийн жилийн орлогын 80 гаруй хувийг Бэрхийн уурхай дангаараа оруулж байсны дээр, уул уурхайн салбарт өндөр мэргэжлийн олон арван инженер техникийн ажилтан, удирдах боловсон хүчнийг бэлтгэн гаргасан байна.

Үйлдвэрлэлийн зориулалтай өргөтгөл шинэчлэлийн зэрэгцээ уурхайчдын нийгэм, соёл, ахуйн зориулалт бүхий 1000 орчим сурагчид хичээллэх боломжтой 10-н жилийн дунд сургууль, сум дундын нэгдсэн эмнэлэг, 280 хүүхдийн ортой ясли цэцэрлэгийн комбинат, 350 хүний суудалтай соёлын ордон, ахуйн үйлчилгээний төв, сувиллын иж бүрэн цогцолбор, гуанз, дэлгүүр, 500 гаруй айлын тохилог орон сууц шинээр ашиглалтад орж, 2000 гаруй хүн амтай Бэрхийн тосгон 1989 онд 10000 орчим хүн амтай Зөвлөлт-Монголын уурхайчид ажиллаж амьдарсан орон нутгийн томоохон хот боллоо өргөжин хөгжсөн байдаг.

Жоншийг олборлох шатнаас боловсруулан баяжуулах шатанд шилжүүлж Баяжуулах фабрикийг 1994 онд ашиглалтад оруулснаар жилд 46.0 мянган тонн өндөр чанарын жонш гаргах боломжийг бүрдүүлсэн байдаг. Түүнчлэн Өндөрхаан-Бэрхийн чиглэлд 1.2 сая долларын өртөгтэй, 110 кВ-ын өндөр хүчдэлийн шугамыг “Монголросцветмет” нэгдэл өөрийн хөрөнгөөр барьж байгуулан, 1997 онд ашиглалтад оруулснаар тус үйлдвэр, хотыг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангаад зогсохгүй, Хэнтий аймгийн зүүн бүсийн сумдыг төвийн эрчим хүчний нэгдсэн системтэй холбох эхлэлийг тавьсан юм.

1994 оноос улс орон зах зээлийн үеийн эдийн засагт шилжиж, эдийн засгийн хүндрэл, дэлхийн зах зээл дээрх жоншны үнийн уналт, худалдан авагч нарын санхүүгийн байдал, далд уурхайн нөөц дууссан зэргээс шалтгаалан олборлолтын ажил бүрэн зогсоож, уурхайг усан консервацид тавьсан байдаг.

Ийнхүү 5000 орчим хүн амтай уурхайчдын хотыг зах зээлийн нөхцөлд авч явах эдийн засгийн хүч үнэхээр хүрэхгүй болж, үйлдвэрийн үйл ажиллагааны алдагдал жилээс жилд нэмэгдэн улмаар далд уурхайг хаахад хүрсэн байна.

1999 оны 5 дугаар сард Засгийн газрын 74 дүгээр тогтоолоор “Монголсовцветмет” /Монголросцветмет/ нэгдлийн бүрэлдэхүүнээс гарч улмаар “Бэрх Уул” Төрийн өмчит үйлдвэрийн газар болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн.

1999 онд Засгийн газрын 74 дүгээр тогтоолоор Чандганы нүүрсний уурхайг “Бэрх Уул” ТӨҮГ-ын бүрэлдхүүнд оруулсан.

## 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

---

2001 онд Засгийн газрын 442 дугаар тогтоолоор “Бэрх Уул” ТӨҮГ-ыг “Бэрх Уул” Хувьцаат компани болгосноор Монголын Хөрөнгийн биржэд бүртгэлтэй болж, улмаар 2005 онд хувьчлагдаж хувийн хэвшлийн хувьцаат компани болон үйл ажиллагаагаа явуулж байна.

2011 онд Дэлгэрхааны жоншны ордод хийсэн өрөмдлөгийн ажлын үр дүнгээр “Бэрх Уул” ХК-ийн эзэмшдэг 166 А ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хамрагдах нөөцийг Монгол улсын Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж ордын үлдэгдэл нөөцийг 56, 46%-ийн дундаж агуулгатай 0,5 сая тонн боломжтой /С/ зэргээр 48.75 %-ийн дундаж агуулгатай 1,6 сая тонн, бодитой болон боломжтой /В+С/ зэргээр 50,52%-ийн дундаж агуулгатай 2,1 сая хүдрийн нөөц, таамаг /Р/ зэргээр 15%-ийн агуулгатай 3,0 сая тонн батлагдсан.

Мөн Micromine компанид хийгдсэн N I 43-101 стандартын дагуу Дэлгэрхааны ордын 166 А ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нөөцийг бодитой /В/ зэргээр 6,62 сая тонн, боломжтой /С/ зэргээр 3,02 сая тонн бодитой болон боломжтой / В+ С/ зэргээр 33,4%-ийн дундаж агуулгатай 9,64 сая тонн гэж баталсан билээ.

Ийнхүү түүхэн хөгжлийн хугацаанд Бэрхийн уурхайгаас Монгол улсын Хөдөлмөрийн баатар 4, Гавьяат уурхайчин 3, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан 3, Сүхбаатарын одон 4, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 8 уурхайчныг мөн Тэргүүний уурхайчин, Алтангадас одонгоор олон уурхайчинг шагнаж урамшуулсан байна

Цаашид Дэлгэрхааны ордыг түшиглэн баяжуулах үйлдвэрийн цогцолборыг байгуулах их ажлыг эхлүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

### КОМПАНИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Тус компани нь Чандган талын нүүрсний орд газар MV-04590, мөн жоншны Баянхаан MV-10965 гэсэн ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг эзэмшдэг бөгөөд уг тусгай зөвшөөрлүүдийн төлбөр хугацаандаа төлөгдөн явж байна.

Компаний үндсэн үйл ажиллагаа нь уул уурхай бөгөөд дараах үндсэн 2 төрөлд хуваана

- Жонш олборлон борлуулах /Дэлгэрхааны хэсэг/
- Нүүрс олборлон борлуулах / Чандганы хэсэг/

### КОМПАНИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

## 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

“Бэрх Уул” ХК нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 19,062,080 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд 100 хувьцаа эзэмшигч манай хувьцааг эзэмшиж байна.

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч давуу эрхтэй этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны хувь
1.	<i>Khanate Resource Holding -3 SARL</i>	6.58 %
2.	<i>Khanate Resource Holding</i>	51.82 %
3.	<i>BEU Holding -SARL</i>	10 %
4.	<i>Khanate Resource Holdings-2 SARL</i>	31.25 %
	Дүн	99.65 %

### НООГДОЛ АШИГ

“Бэрх Уул” ХК нь 2022 онд алдагдалтай ажилласан учир хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашиг олгоогүй.

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

## 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

---

“Бэрх Уул” ХК ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд ердийн 6, хараат бус 3, нийт 9 гишүүнтэй, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороод гэсэн зохион байгуулалтын бүтэцтэйгээр ажилладаг.

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

#### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

---



Раднаа

Бадрах

ТУЗ-ийн дарга

“Хүрээ дэл майнинг” ХХК-д Зөвлөх

---

#### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮД

---



А.Даваажав

ТУЗ-ийн гишүүн

/Нэр дэвшүүлэх хорооны дарга/

“Бэрх Уул” ХК-ийн

Гүйцэтгэх захирал



Б.Наранзаяа

ТУЗ-ийн гишүүн

/Аудитын дэд хорооны гишүүн/

“Хүрээ дэл” ХХК,

“МальФлюорит”ХХК-ийн

Захирал



Б. Баярцэнгэл

ТУЗ-ийн гишүүн

/Цалин урамшууллын дэд хорооны дарга/

“Маль Флюорит ” ХХК-ийн төслийн менежер .

## 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

---



Ө.Алдарбаяр  
ТУЗ-ийн гишүүн  
Говь эрдэнэс энерги ХХК-д  
Захирал



Б.Аригун  
ТУЗ-ийн гишүүн  
“Эм Жи Эл Акуа” ХХК  
гүйцэтгэх захирал, Слүүн  
медиа ХХК үүсгэн  
байгуулагчаар ажиллаж байна.

---

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД

---



Ё.Амарбат  
ТУЗ-н хараат бус гишүүн  
Аудитын дэд хорооны дарга  
Home mortgage corporation  
компанийн гүйцэтгэх захирал



Д.Энхболд  
ТУЗ-н хараат бус гишүүн  
Цалин урамшууллын дэд  
хорооны гишүүн  
Hewlett Packard Enterprise  
монгол дахь төлөөлөгчийн  
бизнес хөгжлийн менежер



Л.Тэмүүжин  
ТУЗ-н хараат бус гишүүн  
Аудитын дэд хорооны гишүүн  
“Хүрээ Дэл Майнинг” ХХК  
Захирал

---

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

#### *Нэр дэвшүүлэх хороо*

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг



## 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

*Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар А.Даваажав, гишүүдээр хараат бус гишүүн Л.Тэмүүжин, Ё.Амарбат*

### **Цалин, урамшууллын хороо**

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин урамшууллыг томьёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

*“Бэрх Уул” ХК-н Цалин урамшууллын дэд хорооны даргаар Б.Баярцэнгэл, гишүүдээр хараат бус гишүүн Д.Энхболд, Ё.Амарбат нар ажилладаг.*

### **Аудитын хороо**

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

*Аудитын хорооны даргаар ТУЗ-ын хараат бус гишүүн Ё.Амарбат, гишүүдээр Б.Наранзаяа, хараат бус гишүүн Л.Тэмүүжин нар сонгогдон ажиллаж байгаа.*

## 2.КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН БАЙДАЛ

“Бэрх Уул” ХК нь 2023 онд Чандганы орд газраас нүүрс олборлон борлуулах, гэсэн үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан.

**Компанийн 2023 оны жилийн орлогын тайлан нь дараах байдалтай байна.**

Орлого үр дүнгийн тайлан	Хэмжих нэгж	2022 он	2023 он
Борлуулалт	сая. төг	1,945.78	1,940.73
ББӨ	сая. төг	1,216.33	1.426.18
Нийт ашиг (алдагдал)	сая. төг	729.44	514.55

## 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Бусад орлого	сая. төг		
Ерөнхий удирдлагын зардал	сая. төг	729.44	864.34
Санхүүгийн зардал	сая. төг	614.54	216.52
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	сая. төг	(323.05)	
Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	сая. төг	(143.96)	
Валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал)	сая. төг	(5,143.74)	872.86
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	сая. төг	(2,985.55)	1,401.56
Орлогын татварын зардал	сая. төг		
Татварын дараах ашиг (алдагдал)	сая. төг	-	

### Санхүү байдлын тайлан 2023

№	Хураангуй баланс	2022 он	2023 он
1	<b>ХӨРӨНГӨ:</b>		
2	Эргэлтийн хөрөнгө	1,187.80	1,324.29
3	Эргэлтийн бус хөрөнгө	7,815.88	6,308.78
4	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,003.68</b>	<b>7,633.06</b>
5	<b>ӨР ТӨЛБӨР:</b>		
6	Богино хугацаат өр төлбөр	27,106.79	27,183.73
7	Урт хугацаат өр төлбөр	10,899.38	8,098.72
8	<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН:</b>	<b>38,006.17</b>	<b>35,282.45</b>
9	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>		
10	Хувийн өмч	3,896.89	1,990.68
11	Дахин үнэлгээний нэмэгдэл		
12	Хуримтлагдсан ашиг	(32,8999.37)	(31,546.28)
13	<b>ЭЗДИЙН ӨМЧИЙН НИЙТ ДҮН</b>		
14	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>9,003.49</b>	<b>7,633.06</b>

## 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Компани нь санхүүгийн тайлан баланс, болон аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны албан татвар, агаарын бохирдлын албан татвар мөн нийгмийн даатгалын тайланг хуульд заасан цаг хугацаанд нь тогтмол гаргаж тайлагнадаг.

*Татвар, нийгмийн даатгалын шимтгэл:2023 онд /төгрөгөөр/*

№	Татварын төрөл	2021 он	2022 он	2023 он	Нийт дүн
1	Агаарын бохирдол	34,046.30	26,046.00	5,257.22	65,349.52
2	АМНАТ	64,579.00	45,236.93	21,587.89	131,403.82
3	ААНОАТ	1,137,306.30		36,908.43	1,174,214.73
4	НӨАТ	105,742.60	192,636.79	82,385.07	380,764.46
5	ХАОАТ	69,779.30	4,338.95	45,160.31	119,278.56
6	Суутган 10	1,622.80		615.00	2,237.80
7	АТӨЯХАТ		1,850.37		1,850.37
9	ҮХХАТ	9,691.80	8,091.54	8,090.34	25,873.68
10	Галт зэвсэг	120.00	152.00	120.00	
11	Газрын төлбөр / Бүгд /	12,115.2	2,215.00	24,473.33	68,803.53
12	Хог хаягдал / Чандган /	669.00			
13	НД-н шимтгэл	211,463.30	64,027.00	242,048.83	292,115.20

Чандганы хэсэг

**ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Чандган талын хүрэн нүүрсний орд нь Нялгын нүүрсний сав газрын зүүн хойд хэсэгт Хэнтий аймгийн Мөрөн сумын нутаг Шорвогийн тал хэмээх газарт оршдог. Улаанбаатар хотоос 290км-г зүүн чиглэлийн мянганы замаас урагш 5км Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотоос баруун хойш 54 км зайд байрладаг.

Тус орд нь дэд бүтцийн хувьд зам харилцаа, цахилгаан холбоо хөгжсөн, хүн ам суурьшсан төв суурин газруудтай ойрхон, эдийн засгийн харьцангуй тааламжтай нөхцөлд оршдог. Газрын гадаргуугын усан сүлжээний хувьд байнгын урсгал ус байхгүй, тогтмол нуур, цөөрөмтэй. Энд тогтсон нуурууд нь хур тунадасны усаар тэжээгддэг давстай нуурууд байдаг. Орд нь зүүн хойноос баруун урагш сунасан 1400-1500м өндөртэй уул нуруугаар хязгаарлагдсан уулс хоорондын далайн түвшнээс 1150-1188м-г өргөгдсөн хөндийд байрлана. Газрын гадаргын хувьд жижиг дов, толгод зонхилсон хотгор, гүдгэртэй тал хээрийн бүсийн шинжтэй гадаргуутай. Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, зун нь харьцангуй дулаахан, 15-35 хэм хүртэл халах ба бороо хурын үед сэрүүвтэр байна. Өвөл нь 25-37 хэм хүйтэн, эхний цас 10-р сарын эхээр орно. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 350мм бөгөөд үүний ихэнх нь 6-8 дугаар сарын хооронд ордог. Салхины чиглэл голлон зүүн хойноос баруун ургаш чиглэлтэй 20 м.с хүртэл хурдтай байна. Орон нутгийн хүн ам ихэнхи нь мал аж ахуй болон газар тариалан эрхлэн үр тариа, хүнсний ногоо тарьж орон нутгийн хэрэгцээг хангана.

Чандганы нүүрсний уурхайг ЗГ-ийн 1999 оны 05-р сарын 02-ны өдрийн 74 тоот тогттолын дагуу “Бэрх Уул” ХК-ийн бүрэлдэхүүнд нэгтгэсэнээс хойш өнөөдрийг хүртэл хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг явуулж Хэнтий аймгийн төв болон зарим сумдыг нүүрсээр ханган тасралтгүй ажиллаж ирсэн.

Тус уурхайн олборлолтын хэмжээ нь Хэнтий аймаг болон бусад сумдын хэрэглэгчийн жилийн хэрэгцээнээс шууд хамааралтай.

## 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### Чандганы хэсгийн 2022 оны борлуулалт үйл ажиллагаа

Чандганы нүүрсний уурхай нь орон нутгийн чанартай нүүрсний уурхай тул дотоодод буюу Хэнтий аймгийн төвийн болон бусад сумдын аж ахуй нэгж, хувь хүмүүст жилийн 1-4, 10-12-р саруудад нүүрс олборлон борлуулдаг.

2023 онд төвлөрсөн халаалтын зуухнууд болон үйлдвэр аж ахуйн газарт 57,228 тн нүүрсийг олборлон борлуулсан.

№	Төрөл	Хэмжих нэгж	2021	2022	2023
1	Нүүрсний борлуулалт тн	тн	67,000	58,703	57,228
2	Нүүрсний борлуулалт /төг/	сая.төг	1,879,983	1,945,780	

### Хөрс хуулалт

“Бэрх Уул” ХК-ийн Чандганы нүүрсний уурхайн хэсэг нь хөрөнгө санхүүгийн байдлаас шалтгаалан техник шинэчлэлт хийж чадаагүй, мөн уул геологийн нөхцөл хүндэрсэн зэргээс шалтгаалан сүүлийн 2015-2020 онд иргэн, аж ахуй нэгжээс техник тоног төхөөрөмж түрээслэж хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэж байсан.

Компани нь хөрс хуулалт болон цаашдын үйл ажиллагаанд зориулж автосамосвал 2 ширхэгийг 91.5 сая төгрөгөөр 2020 оны 5-р сард худалдан авсан.

2020 оны 6-р сарын 1-нээс хөрс хуулалтын ажлыг эхэлсэн боловч байгаль цаг уур, хөрөнгө санхүү, мөн техникийн дутмаг байдал /Экскеватор/ эвдрэл, гэмтэл зэргээс шалтгаалан төдийлэн сайн гүйцэтгэж чадалгүй 2020 оны 7-р сарын 3-с наадмын амралтыг эхлүүлсэн.

2020 оны 7-р сарын 27-нд Doosan-500 экскеватор-г иргэн Амгалантөрөөс “Тоног төхөөрөмж худалдан авах гэрээ” №ХХАГ-01/2008 тоот гэрээний дагуу 250,0 сая төгрөг, төлбөрийг 3 хувааж төлөх, гэрээний үлдэгдэл төлбөрт сарын 2% хүүтэйгээр зээлээр худалдан авсан.

Өмнөх жилүүдийн хөрс хуулалтын ажилд экскеватор, автосамосвалл зэрэг техникийг иргэн аж ахуйн нэгжээс түрээслэдэг байсан бол энэ жил экскеватор түрээслэлгүй зөвхөн автосамосвалл 4-г түрээслэж хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэснээр түрээсийн зардал болон хөрс хуулалтын коэффициентийг бууруулж өгсөн.

## 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

---

Ингээд тус уурхайн хамт олон 2022 оны 10-р сарын 15-гэхэд хөрс хуулалтын ажлыг бүрэн дуусгаж 2022-2023 оны халаалтын циклд Хэнтий аймгийн хэрэглэгчдийг нүүрсээр ханган ажиллаж байна.

### ***Техник тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ***

Тус уурхай нь дараах техникүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- KOMATSU-D155A, KOMATSU -D65A /Бульдозерууд/
- DOOSAN эксковатор, /300.500/
- ZL50C-автоачигч 2 ширхэг
- Ланд Крусер 78-1 ширхэг
- Запрушка-1 ширхэг
- Автосамасвол-2 ширхэг

Зэрэг техникүүдээр 2022 онд уурхайн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Автоачигч, бульдозер, эксковатор зэрэг техникүүдийн ашиглалтын хугацаа дууссан, явах эд анги болон бусад эд анги муудсан зэргээс шалтгаалан техник эвдэрч байсан бөгөөд дараах засвар үйлчилгээг хийсэн

Техник тус бүр дээр дараах зардлууд гарсан байна.

### ***Уурхайн дэд бүтэц, тохижилт, туслах аж ахуйн хүрээнд***

- 08 сард Бэрх хотын хогийн цэгийг хашаажуулж, хур хог хагдлыг түрж булаах ажлыг хийж гүйцэтгэсэн
- 2023.12-р сард Хэнтий аймгийн Мөрөн сумын халажийн төвд 70тн нүүрс хандивласан
- Засварын багаж, тоног төхөөрөмж хийх, хадгалах байрны засварын ажлыг
- “Бэрх Уул” ХК-ийн ажилчид тус бүрт 3тн, Бэрхийн далд уурхайн музейд 100тн, Батноров сумын ЗДТГ-т 35тн нүүрс тус тус хандивласан.
- Ажилчдын хоол хүнсэнд төмс, манжин, лууван, сонгино тарьсан
- Улиас, царгас тариалсан.
- Чандганы оффисын дотор өрөөний хуваарилалт, бүтцийг өөрчилж засвар хийж тохижуулав

- Оффисын дотор хөнгөрөөр бие засах ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө гаргаж тохижуулав.
- Чандганы уурхайн карьеруу 380 вольтийн цахилгаан татав.
- Цооног өрөмдөв
- Чандганы объектуудын харуул хамгаалалт, камержуулалтыг сайжруулав
- Шинээр ХХАБ-ын өрөө байгуулан тохижуулав

Чандганы уурхайн ажилчдыг хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцсаар хангаж, хор саармагжуулах сүү, аарц, чацарганы шүүсийг хоол хүнсэндээ тогтмол хэрэглэж байна.

“Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм зааварчилгаа”-г байгууллагын онцлогт тохируулан боловсруулж мөрдөн, ажилчдад ХХАА-ны дүрэм журмыг тогтмол өгч, гарын үсгээр баталгаажуулан ажилладаг.

### **Хүний нөөц, боловсон хүчин**

2023 оны тус компани нь Захиргааны хэсэгт-4 ажилчин, Чандганы нүүрсний уурхайн хэсэгт-15 ажилчин, Харуулын албаны хэсэгт-9 ажилчин гэсэн бүрэлдэхүүнтэйгээр, нийт 29 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс эмэгтэй-9, эрэгтэй-20 ажилчидтай.

Тус онд ажилчдаасаа мэргэжлийн гагнуурчин, компанийн засаглал зэрэг сургалтанд хамруулсан.

Тус компани нь “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг боловсруулан үйл ажиллагаанд мөрдлөг болгож, 2 жил тутам шинэчилдэг. Ажил олгогчийн зүгээс ажилтан бүртэй Хөдөлмөрийн гэрээ байгуулж, шинээр орсон ажилтантай 3 сар хүртэл туршилтын гэрээ байгуулан ажиллуулдаг. Мөн ажиллагсдын цалинг сар бүрийн сүүлийн 7 хоногт олгож, нийгмийн даатгалын дэвтэрт үнэн зөв бичилт хийн баталгаажуулж ирлээ.

### 3.НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛУУД

#### *2023 оны онцлох үйл явдлууд:*

- Монголын уул уурхайн салбарын 100-н жилийн ойг тохиолдуулан хийгдэж буй далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв буюу Бэрхийн далд уурхайн музейн ажилд зориулан “Бэрх-Уул” ХК-ийн нэрэмжит танхим өрөөг тохижуулах ажил хийгдэж байна.
- Бэрх Уул” ХК-ийн төв оффисын урд талбайд чулуу суулган засаж, хашааны үүд хэсгийг чулуугаар хийж орох гарцыг өөрчлөв.
- Бэрх Уул” ХК-ийн төв оффист босоо душ, суултуур, угаалтуур суурилуулан ариун цэврийн өрөөг шинэчлэн засварлаж тохижуулав.
- Бэрх Уул” ХК-ийн төв оффисийн хуучирж муудсан, өрөө тасагаа, коридорыг шинэчлэн засварлав.
- Бэрх Уул” ХК-ийн төв оффисын хуучирж муудсан шалыг сольж паркет хийв
- Бэрх Уул” ХК-ийн төв оффисын гадна машин зогсоолыг даацын хавтан тавьж засав.
- Бэрх Уул” ХК-ийн төв оффисын урд талбайд хүндэтгэлийн гэрийн урд талбайд чулуу суулган засаж өөрчлөв.
- Чандганы уурхайн хэсэгт техник шинэчлэлт хийсэн
- Чандганы хэсэгт ажилчидын хүнсний ногоо тариалж өөрсдийн хэрэгцээг хангасан
- Малын тэжээлд царгас, ажилчдын амжиргаанд чацарганы мод тариж нутагшуулж байгаа
- Чандганы хэсгийн ажилчдын байр, гал тогооны зөөврийн усны асуудлыг бүрэн шийдсэн
- Чандганд шинээр ХХАБ өрөө байгуулан тохижуулсан
- Аюулгүй байдал, харуул хамгаалалтандаа анхааран бүрэн камержуулсан



### *Нийгмийн хариуцлагын хүрээнд*

Тэмдэглэлт баярын өдрүүд, шуурхай гэнэтийн үйл явдлыг тохиолдуулан Бэрх хотын захирагчийн албатай хамтран ажиллах, арга хэмжээнүүдийг зохион байгуулах, хандив зэргээр олон нийтийн оролцоог ханган ажиллав.





## 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



“Бэрх Уул” ХК-ын ажилчид байгалиа нөхөн сэргээх, хамгаалахад гар бие оролцож, ойн сан, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор Мөрөн сумын Чандгана багт байрлах Чандганы уурхайд 1 га газарт царгас тарьлаа.



## 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

---

Нийгмийн хариуцлагын хүрээнд Ардын хувьсгалын 103 жилийн ой, Батноров сумын үндэсний их баяр наадмын үйл ажиллагаанд хандив өгөв. 2023.07.11



Үндэсний сурын харвааны нээлттэй тэмцээнийг “Бэрх уул” ЖК-ийн нэрэмжит болгон ивээн тэтгэж, цаашид уламжлал болгон зохион байгуулахаар боллоо. 2022.08







### КОМПАНИЙН ИРЭЭДҮЙ, ТӨЛӨВЛӨГӨӨ

“Бэрх Уул” ХК-ийн ирээдүйн хэтийн зорилго нь орчин үеийн техник технологийг, мэргэшсэн боловсон хүчний ур чадвар, хүсэл тэмүүлэлтэй хослуулан Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, стандартын хүрээнд, хэрэглэгчийн чанарын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг өндөр бүтээмжтэй үйлдвэрлэн олон улсын жоншны зах зээлд өрсөлдөхдөө хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, компанийн ажиллагсад болон нутгийн иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэндэд хохирол учруулахгүй, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах зорилго тавин ажиллах болно.

Бид олон улсын зах зээл дээр жонш, олборлон борлуулах дэлхийн хэмжээний үйл ажиллагаатай үйлдвэрлэгч компани болж, Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна.

